

2.16. ЖАЛХАНЗ ХУТАГТ ДАМДИНБАЗАРЫН ШАШИН, НОМЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРИМ АСУУДАЛД

Түлхүүр үг: Жалханз хутагт; шашин, төрийн зүтгэлтэн; хутагтын өмнөх дүр; самади багш; номун хан; номыг шүтэж, ухаанаа мэргэжижүй; цогдам (tsogs gtam); их хутагт; гэгээнтэн.

Оршил

Монголын орноо дээдийн ном гурвантаа дэлгэрч монголын нийгэм, соёл, хүн зоны ахуй амьдралд дасан идээшиж, өөрийн гэсэн ая дан, өвөрмөц нэгэн байдлаар монголын хөрснөө баяжин дэлгэрч, ...монгол хүний нийгэм оюуны амьдралын салаа бүхнийг хамарч, ахар богино хугацаанд өргөн бөгөөд гүнзгий нэвтэрч шингэснээрээ онцлог болно¹. Ийн дэлгэрэн ахуй дор анх язгуур гарваль нь Энэтхэг, Төвдийн орноос улбаатай шашны томоохон зүтгэлтэн, их мэргэдийн хойд дүрийг Монгол газар орноо тодруулан хутагт, гэгээний ширээнээ залсан буй. Тэдгээр нь мөнхүү олон олноор дараалан тодорч өмнөх үеийн хутагт, хувилгаадын олон нийт хийгээд шашны бодлого, үйл ажиллагааг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байсан буй.

"Зарлигаар тогтоосон олон аймгийн тамга бүхий, үгүй хутагт хувилгаан нарын шастар"-т нийт 60 гаруй хутагтын товч намтрыг, өмнөх дүрүүдийн хамт хураан өгүүлсэн байна. Дурдсан сурвалжид өгүүлэх хутагтууд нь дор бүрнээ монгол газраа хоёроос доошгүй удаа хувилан тодорсон байх аж.

Хутагт, хувилгаадын нэгэн нь, Монголын орноо наймантаа тодорсон самади багш, номч мэргэн егүзэр бандида, жалханз хутагт Дамдинбазар болой. Тэрвээр монголын шашин, төрийн томоохон зүтгэлтэн болох хувьд нь түүхэн бие хүн гэдэг талаас нь басхүү багагүй судалжээ²

¹ Монголын философийн түүх (XVII-XIX зуун) III дэвтэр. Ред: Лхагвасүрэн Г., Дашжамц Д., УБ.,2001, 109 дэх тал

² Хоёр их хутагт, УБ.,1995-эмхтгэлд буй Батсайхан О., Лааган Б., Лонжид З., Очирбат Г., Пүрэв О., Хүрэлбаатар Л., нарын өгүүллүүд; Болдбаатар Ж., Монгол улсын засгийн газрын тэргүүн, УБ., 95-101 дэх тал; Дашбадрах Д., Монголын хутагтууд, УБ.,2004; Лааган Б., Жалханз хутагт Дамдинбазар, УБ.,1994,-Халхын тамга бүхий хутагтуудын товчис, УБ.,2004, 53-66 дахь тал; Нямсүрэн Л., Общественно-политическая деятельность Жалханз хутагт Дамдинбазара (1874-1923) -Автореферат диссертации на соискание ученой степени доктора (Ph.D) по истории, УБ.,2005; Очирбат Г., Завхан аймгийн түүх (XVII-XX) УБ.,2003,- Хутагтууд бүлэг,-Жалханз хутагт Дамдинбазар 1911 оны Монголын үндэсний хувьсгалын удирдагчдийн нэг мөн,-Жалханз хутагт Дамдинбазарын багш шавийн барилдлага болон номын ёсыг сахихуй, Манай монгол сэтгүүл, УБ.,1999№04, 2005№01; Хүрэлбаатар Л., Огторгуйн цагаан гарьд, УБ.,1996,-Шимнусын омгийг очроор дарагч, 306-316 дахь тал.

Харин энд хутагтыг шашны зүтгэлтэн, сахил хүртсэн санваартан болохын хувиар нь гэгээнтний ойрын шавь Агваанлхасүрэнгийн 1928 онд туурвисан "Гэтэлгэгч лам Жалханз их эрдэнэ Лувсанданзанжалцандамдинбазарбалсамбуугийн нууц гурван гайхамшигтаас гарсан намтар, зуун дэлбээтийн цэцэрлэгээс хувь төдийг өгүүлэн үйлдсэн цагаан лянхуан баглаа сайн чуулганы үүдийг нээгч хэмээх оршивой", Вангай равжамба хэмээх Агваанлуvsан-Иштүвдэнгийн 1863 онд бичсэн "Шашныг ихэд гийгүүлэн үйлдэгч Жалханз их эрдэнэ богд Лувсанбалжирлхүндэвийн намтар, сайн хувьтны чихний шимийг авахуй хэмээгдэх оршивой" хэмээх төвд судар хийгээд судалгааны бусад сурвалж хэрэглэгдэхүүнд эш үндэслэн зарим зүйлийг өгүүлсү.

Жалханз хутагтын дүрүүдийн тухайд:

Олон аймгийн хутагт, хувилгаадын шастарт: Уг эхийг байцааваас Энэтхэгийн оронд Базарваань, Цогтсарха, Зундуй-Ёндон, Их Түгээмэл Гүндүү, хан Махасуха, Чойгүцагаан, Чимэдманбадар хэмээн долоон үеийн хувилгаан гарчээ. Түүний хойно Төвдийн оронд Дүвчин Намхайжанцан, Батлуав хэмээх Мижиддорж, Жамагарбо, Жамьянмолмпил, Балжиржамц, Чойжиржамц хэмээн зургаан үеийн хувилгаан гарчээ. Түүний хойно Лувсанданзанжамц, хятадын Зүнжинг хааны дөрөвдүгээр онд Засагт хан аймагт хувилгаан тодорчээ. Дараа үеийн жалханз Лувсанданзанбалсан, Галсандамба-Яримпэл, Лувсанбалжирлхүндэв, Чоймболжалцан, Чойжилжалцан, Дамдинбазар гэсэн долоон дүр тодорсон хэмээн өгүүлсэн байх¹.

Доктор Л. Хүрэлбаатар авгайн "Жалханз хутагтын төвд намтарууд, түүнд хийсэн зарим ажиглалт" гэсэн намтруудын судалгаа, "Шашныг гийгүүлэн үйлдэгч Жалханзын хувилгааны дүр, төрөл үеийн бишрэл, төгөлдрийн сүсгийг төлжүүлэгч хэмээгдэх оршивой" хэмээх төвд судар зэргээс үзэхүл: Лувсанданзанжамц, Лувсанданзанбал, Ишгэлэг,² Галсандамба-Яримпэл, Лувсанбалжирлхүндэв,

¹ Зарлигаар тогтоосон Монгол улсын шастар, Дэвтэр II,-Зарлигаар тогтоосон олон аймгийн тамга бүхий, үгүй хутагт хувилгаан нарын шастар, дэд доорд, 38-39 дэх тал

² Түнрав солдив ('khrungs gabs gsol 'debs)-д "...Нэгэнт амьтны цог дор сайтар сүндэрлэн боссон номч Ишгэлэгийн өлмийд соёрхол талбимой" хэмээснээс Жалханз хутагтын нэгэн дүр гарч ирж байна. Сударт буй ёсоор болбоос II дүрийн бүрэлбаа мэт харагдах авч он цагийн дагууд нь нягтлан үзэхүл III дүрийн хутагт болно. Учир нь "Зарлигаар тогтоосон хутагт, хувилгаадын шастар"-т хутагтын II дүр тэнгэр тэтгэсний 5-р он (1740)-д жанч халж, дараа дүр нь тэнгэр тэтгэсний 11-р он (1746)-д мэндэлсэн гэх нь даруй таван жил хутагт сэнтий оргүй байсан болохыг нотолж байна. Доктор Л. Хүрэлбаатар: "Хотгойд таван хошууны өтгөс өвгөдийн аман бөгөөд амьд уламжлалаар найман дүр гэж үзэж гүдэн шарилыг нь хүртэл тоолж, мэдээлж ирсэн аман уламжлалд Жалханзын таван настай ширээнд залаад, 16 хоноод таалал төгссөн нэг хүүхэд дүр байсан тэр дүрийн гүдэн шарилыг Шадар ван Цэнгүнжав (Цэгонжав буюу Гонжав) хайрцаг савтай үүрч явсан" гэж тэмдэглэсэн буй. Бас нэгэн зүйл болбоос, V жалханз Лувсанбалжирлхүндэвийн намтарт дээрхийг тодотгох баримт нь, тэнгэрийг тэтгэсний 11-р онд мэндэлсэн Галсандамба-Яримпэлийг IV дүрийн бүрэлбаа мөн хэмээж сунтаг шүүлгэхэд, Шадар ван өөрийн албатаас мөн онд төрсөн Бодь нэрт хөвүүнийг Жалханзын дараа дүр мөн гэж хоёр хөвүүний

Чоймболжалцан, Чойжилжалцан, Дамдинбазар гэх найман дүр тодорсон болох нь нотлогдож байна.

Найм дахь үеийн бүрэлбаа Жалханз¹ хутагт Дамдинбазар нь Засагт хан аймгийн Хотгойд гүн Загдсамбарын хошуу нутаг Алтанбулагийн хавьд орших Бугын толгой гэдэг газар Манж бүрэн засагч хааны арвангуравдугаар (1874) он, модон нохой жилийн зуны эхэн сарын хорин есөнд лагшин мэндэлжээ.

Номыг шүтэж, ухаанаа мэргэжихүй:

XV дугаар жарны хар усан луу жил, Халхын Их хүрээний Гунгаачойлин (kun dga' chos gling) хэмээх гүн ухааны дацан сургуульд ирэн ухаанаа мэргэшин буй нас бие тэгширсэн залуу шавь болбоос Засагт хан аймгийн тамга бүхий хутагтын нэгэн бөлгөө, самади багш, номун хан, түгээмэл сайд, гүжир хамбо, номч мэргэн егүзэр бандида, жалханз хутагт Дамдинбазар байлаа².

Гэгээнтэн нь номыг болгоогч багшийн тухайнаа: "Хутагтын их нэр зүүж багаасаа торгон дээлд боолгон ном эрдмийг ч эрхэлдэггүй муу зуршлаас ангид байлгах гэж миний багш намайг барьж хүмүүжүүлсэн"³ хэмээн айлдсан буй. Тэрвээр анханд их хүрээний аграмба Жигжид, бишрэлт вангийн хошууны эрдэмтэй лам Агваанжамбалжалцан бас аграмба Пунцаглхүндэв тэргүүтэн эрдэмт лам нарыг шүтэж эш онолд суралцан бичиг үсэг, ам уншлага, онол чойрын анхны мэдэгдэхүүн, янзан бүрийн эрдэм номыг үзүүлжээ. Ер нь хутагт, хувилгаад төдийгүй эрдэм мэдлэг бүрнээ цогцолсон лам нугууд ч мөн эрдэмт лам, мэргэдийг шүтэн тэднээс номын эш, лүн,

нэрийг Төвдийн VII далай лам Галсанжамц (1708-1757)-аар сунтаг шүүлгэхэд Галсандамба-Яримпэлийг мөн хэмээсэн хийгээд эл дүртэй Шадар ван ихэд таарамж муутай байсан тухай өгүүлсэн байна. Дээрхи бүгд нь он цагийн дагууд тохирч буй учир III жалханз хутагтыг Ишгэлэг гэж үзэх бүрэн үндэстэй юм.-Хоёр их хутагт, эмхтгэл, 14 дахь тал.

¹ "Rgyal khang rtze" гэдэг нь угтаа "ялгуусны байшингийн орой, дээд" гэсэн утга бүхий төвд үг юм.

² Манжийн Төр гэрэлт хааны 4-р онд Зарлигаар "Халхын Засагт хан аймгийн Жалхан хутагтын тамга" гэсэн Манж, Монгол, Төвд гурван зүйлийн бичиг бүхий алтан үсэгтэй тамгыг V жалханз Лувсанбалжирлхүндэвд соёрхсон. Зоригт бэйлийн хамт нийлж, Дөрвөд, Урианхайн олон хошуудыг тулгар төрд дагаар оруулсан ба бэхэлсэн хотыг дайлан сөнөөхөд ном уншиж онц хүчин зүтгэсэн учир сайшаан хөхүүлэхийг эрж айлтгаад Зарлигаар "Самади багш" цолыг, төмөр барс жил (1890) Хутагт бээр анх Богдод бараалхсанд "Хамба номун хан" цол магтаалыг хайрлаж хамбын зэрэг олгон, бурханы рид хувилгааны тухай зохиолыг үзүүлэв. Шар сүмд суухдаа амьтанд тустай зүйл бүтээсэн, ялангуяа сүмийг засч шинэ болгосонг нь үнэлж Манж хаанаас "Түгээмэл сайд" гэдэг нэр шагнаж олгосон алтан үсгийн бичгийг гардуулсан. Усан луу жил (1892) Хутагтыг Богд гэгээнтэн дэргэдээ дуудан ирүүлж "шадар хамба"-аараа ажиллуулахаар болж "Миний санасан бүх хэргийг та бүтээх хэрэгтэй" гэхчлэн маш чухал учир шалтгааныг дотночлон ярьсан хийгээд Хутагт бээр багшийн зарлигийг бүтээхээс илүү анхааран авалт гэж үгүй, шашин амьтны тусад буян үйлдэхээс илүү зүйлгүй гэж санаад зарлигийг шууд хүлээн авав гэж намтарт дурджээ. Олноогийн 8-р онд Цогчин дуганы үйлдвэрт мөнгө туслан барьсан учир айлтгаад Номч мэргэн егүзэр бандида цол шагнаж хүртээжээ (Г.М)

³ Агваанлхасүрэн., Цагаан лянхын баглаа сайн чуулганы хаалгыг нээгч, УБ., 1994, 8 дахь тал.

ван, жананг авч түүнээ оюундаа бясалган бүтээдэг, буцаагаад олонд номлон айлддаг тухайд сан-ег (gsan yig-сонссоны тэмдэглэл)-т нь тодорхой гарч байдаг.

Жалханз хутагт Дамдинбазар ном ёсны цогдам (tsogs gtam-хурлын үг)-ыг их хийдэг хүн байв. Гэгээний үг нягт бөгөөд сүр, хүч ихтэй байсан тул ёс дэглэмтэй харшилдсан хүнийг цээрлүүлэх, ёс журмаар явагчдыг магтан сайшаадаг хурц хүн...¹ түүнчлэн гэгээн өөрийн айлдсан ёс жаяг нугуудаа өөрөө хурал гэсгүүлж (dge bskos-буяныг захирагч) айлддаг асан тухайд ч намтар тэргүүтэнд дурдсан буй.

Хутагт бээр өөрийн үед амьдарч асан дилова хутагт Жамсранжав, бигэр номун хан Ванчинсүрэн, ялгуусан хутагт Чимэдцэрэн нартай ойрноо уулзан харилцан ном хүртэхийн зэрэгцээ өөрийн хүрээ хийднээ дутууг залан авдаг байжээ. Тухайлахул, өөрийн хүрээндээ Майдарын тахилын чамийг буй болгохыг таалж, Ялгуусан хутагтын хүрээнээс ловон Жанжааг авчруулан чамын хэрэглэл, дэгийг заалгажээ.²

Ер бүх дүрийн Жалханзууд бурханы номноо бүрнээ нэвтэрсэн эрдэм төгс хутагт байсан тухайд хутагтуудын намтар тэргүүтэнд олонтоо дурдсан байна. Нэгэн зүйлд тодруулахул: Машид согтонги хэмээх цагаан морин жил (1810) Жалханз хутагт Балжирлхүндэв бээр Пунцагдаржаалин дацанг байгуулж, маналын чого хурдаг болгов. Улаан хулгана жил (1816) ханчин номун хан Лувсанцэвээнжавцогбалсамбуу ламаас банчин эрдэнэ Лувсанчойжижалцан, Балдан-Иш, ялгуусан Галсанжамц, жанжаа хутагт Агваанчойдан, Ролбийдорж, жавзундамба Лувсантиүвдэнванчүг тэргүүтэн олон лам нарын сүмбүмээс ном ихийг сонсчээ. Дараа онд нь уг ламаас гэлэн сахил авсан хийгээд түүнээс Винайн ном ихийг сонсов. Цагаагчин хулгана жил (1840 он) Халх богд (V богд Лувсанчүлтэмжигмэддамбийжалцанбалсамбуу)-д Зонхава богдын сүмбүмийн аман эш өгсөн хийгээд Богд хариуд нь мөн лүн хайрласан. Шинээр байгуулагдсан Гандантэгчилэн (dga' ldan theg chen gling)-д Богд бээр олон хуврагуудад Жалханзаас сонссон номоороо лүн талбив. Түүнд нь Жалханз хутагт байсан хийгээд Богд бээр гэгээнтний гавьяаг их гэж ерөөсөн гэхээс харагдах³.

Модон нохой жил (1905 он) Жалханз гэгээн Дамдинбазар 32 настай. Зун нь Далай гүн Базаррагчаагийн хийдэд морилж аграмбын дамжааг шинээр дэглэн байгуулж өгөв. ...Гэгээн зүй нь энэ зун их хүрээнээ Гунгаачойлин дацанд гавжийн дамжаа барих ёстой байв. Гэтэл өөрөө: “сургууль хийгээгүй байж мяндгийн хэрэг юун”

¹ Агваанлхасүрэн., Дурдсан намтар, 22 дахь тал.

² Агваанлхасүрэн., Дурдсан намтар, 21 дэх тал.

³ Ngag dbang blo bzang Ye she thub bstan., Bstan pa'i gsal byed chen po Rgyal khang rtze rin po che rje Blo bzang dpal 'byor lhun grub kyi nam par thar bskal bzang rna ba'i bcud len zhes bya ba bzhugs so., 19a, 23a, 6, 31b, 32a.

гээд уул дамжааг барьсангүй гэж тэмдэглэсэн буй. Энэ нь гэгээнтэн гурван жилийн өмнөөс Ховдын Шар сүмийн тэргүүн ламаар Манжийн хааны зарлигаар суух болсон хийгээд Богд гэгээнтний дуудлагаар ойрхноо Их хүрээнээ хүрэлцэн ирж гүжир хамбын ажлаа гүйцэлдүүлэх гэхчлэн төр, олон нийтийн ажил их байсантай холбоотой агаад нэр төрийн алдраас зайлсхийдэг болохыг гэрчлэн буйн хэрэг. Лавшруулан дурдахул, "...эрх тушаалдаа эрдэж бардах, сагсуурахгүй, үргэлж олон түмний төлөө бодож, өөрийн хэргийг бүүр мартаж аль зөв шударга үйлийг баримтлан ажиллах хэрэгтэй"¹ хэмээн айлдсанаас нь илэрхий.

Жалханз хутагтууд нь Монголын шашны тэргүүн богд Жавзундамба хутагттай ойрд нөхөрлөн, нэгэн багшаас номын ухаанд суралцах, харилцан бие биенээ лүн өгч байсан зэрэг нь ихээхэн сонирхол татаж байдаг. Дамдинбазар хутагт Богдын багш гонсор бүрэлгүү Лувсанбалданчоймболд шавь орж, тэр ламаас Богд ламын "Га", "Па", "Ба", "Ма" дөрвөн сүмбүмийн лүнг Богдын хамтаар цуг суун хүртэж байжээ².

Жалханз хутагт Дамдинбазар богдын дэргэд байхдаа түүний зарлигчилсан бүх ажил үйлийг чин үнэнчээр гүйцэтгэж байв. Үүнд нь Богд маш их баясаж, хутагтад хөх бүс, нандин пүрэв хоёрыг биедээ авч яв гэж өгчээ. Мөн өндөр Богдын өөрийн гараар урлан хийсэн Гомбо бурхан, Арлозавагийн гавал эрих, Бунтар богд тэргүүтэй ховор шүтээн олныг хайрлав. Бас голын шар хашааны зүүн талд орд бариулж "Шашин хэзээ буй цагт энэ орд байсугай" гэжээ. Түүнчлэн Жалханзын хүрээний "Равданчойнхорлин" (rab brtan chos 'khor gling)-гийн жаяг дүрмийг Богд бээр өөрөө зохион донир (don gyur) Нямаагаар хүргүүлснийг Дамдинбазар гэгээнтэн хийддээ хүндлэн хүлээн авч баяр хурим хийв. Тэр жилээс эхлэн жил бүрийн өвөл, зуны тогтмол хурлын Доромжанлав (gtor ma byin rlabs) хурах өдөр гэсгүй тэр жаягийг уншиж цогдам айлтгаад, лам нартаа жаягчлан явахыг үүрэг болгон даатгаж өгдөг заншилтай болжээ³.

Гэгээнтэн судар тарнийн ном, ёсыг улам дэлгэрүүлэх энэ үйлсэд бусдыг хичээн шамдаж оруулахад ихээхэн анхаарч, тухайлахул, бурханы бие, зарлиг, тааллын шүтээнийг шинээр босгох, хуучныг засаж сэлбэх, ном зохиох, сонсгох тэргүүтнийг улам дэлгэрүүлж, дүг өргөх зохион байгуулалт бий болгожээ. Нэгэн зүйл: Сандижигсүм (gsang bde 'jigs gsum)-ийн бүрэн дүг өргөсөн хүнд сайн морь нэг, түүнчлэн гавж, аграмбын дамжаа барьсан хүнд нэг толгой торго, бурхан шүтээн босгосон, судар залсан, суварга бүтээсэн лам нар, өргөл хүндлэл өргөсөн хүнд тус

¹ Агваанлхасүрэн., Дурдсан намтар, 36 дахь тал.

² Агваанлхасүрэн., Дурдсан намтар, 11 дэх тал.

³ Агваанлхасүрэн., Дурдсан намтар, 12-13 дахь тал.

бүрт нь их, багын хэмжээгээр гарын бэлэг, зангиа, утлага, хадаг зэргээр шагнадаг болсон байна. Буян номын энэ үйлсэд лам хувраг, эргэл мөргөлчин олноор хамрагддаг байсан ажгуу.

Басхүү хүрээний бүх лам нарыг хамбаас эхлэн цөм хийдийн жаяг, дэглэмийг чанд хатуу сахих үүрэгтэй болгож, таван ботийг аль чадахаар мэдэхийн тулд шамдах, хийдийн дэглэмээс харштай зүйл үйлдэгчдийг жаягчлан шийтгэх, бүгдээрээ хоорондоо зохицож ажиллах, хэн боловч шашин төрийн үйл хэрэгт шүтэн шамд, сэтгэл шургуу байх хэрэгтэй хэмээх цогдамыг дахин дахин айлддаг асан тухайд намтарт дэлгэрэнгүй өгүүлжээ.

Номын хур буулгаж, буяныг хураахуй:

Жалханз хутагтын нийт олны тусад зориулсан буян нь цаглашгүй хийгээд намтарт өгүүлж буйгаар бол Хутагтыг очсон газар бүрт өглөгийн эзэн, эргэл мөргөлчин олон олноор бараалхах хийгээд үүр цайтал тэднийг хүлээн авч уулзах бөгөөд ул уцаарлан байх авай. "Их ачтай хүн" хэмээн нэр нь түгсэн хийгээд, Гэгээнтэн "Зохионгуй явдалд орогч" хэмээх номондоо:

Гаслант сэтгэлийг баярлуулах болтугай

Гансарсан сэтгэлийг нь сэргээх болтугай

Айгч нарыг аюулгүй болтугай

Хүлэгдэгчдийг хүлэг нь тайдагдтугай... хэмээсэн нь дээрхийг нотлон өгүүлэх хийгээд тэдний тусад ямагт ерөөл тавьж байдгийг харуулах амой.¹

Хутагт бээр хэд хэдэн ном бичсэн болох нь намтраас харагдах бөгөөд зөвхөн барлагдан гарсан /барлагдаагүй гар бичмэлээр үлдсэн/ номын нэрсийг дурдваас:

1. Bshes gnyen bsten tsul (Багшийг шүтэх ёсон)

2. Shes rab 'khor lo (Бэлгийн хүрд)

3. Gzhan phan snying po (Бусдад туслахын зүрхэн)

4. Ye shes me dpung (Бэлгэ билгийн гал)

5. "Dcd 'jo bum bzang (Хүсэл хангагч сайн хумх)

6. Mtson ch 'khor lo (Бэлгэ, бэлгэдэхүүний хүрд)

7. Rin po che'i gter stzol (Эрдэнийн сан хайрлагч)

8. Byams pa'i rol mtso (Асрахуйн цэнгэлт далай) тэргүүтэн найман ном буй.²

¹ Агваанлхасүрэн., Дурдсан намтар, 26 дахь тал.

² Агваанлхасүрэн., Дурдсан намтар, 41-42 дахь тал.

“Жалханзын хүрээ”-нд Гэгээнтэн хэд хэдэн сүм дуганыг шинээр бий болгож, бариулсан байна. Дурдваас:

1. Цагаан хашааны ар талд Чагдардорчин (chyag rdor gtor chen)-гийн дуганыг шинэ бариулж Пунцаглин (phun tsogs gling), Чойендэчинлин (chos dbyings bde chen gling) дацныг байгуулав.
2. Түүний баруун талд Шалш (zhal zhi)-ийн дуган Гипиллин (dge 'phel gling)
3. Зүүн талд нь шармал том Жамсран (lcam sring)-гийн сүм
4. Түүний өмнө нүүрэнд Гүнсэмповрон (kun bzang pho brang) хэмээх гэр хэлбэртэй сүм
5. Поврон, түүний баруун нүүрэнд их Лавран (bla brang)
6. Түүний баруунд сүмбүм (бүрэн зохиолын ном залсан) сүм
7. Түүний өмнө их сэнчин (зуны орд)
8. Түүний өмнө зүүн нүүрэнд их Лавран (цомцог)
9. Тэдгээрүүдийн өмнө нүүрэнд үүднийх гэдэг их поврон гэх мэт. Эдгээр нь уран гоё, угалз хээ, будаг зэргийг хачин сайхан тааруулжээ. Дуган сүм дотор дутуу юм нэгээхэн бээр үгүй ажгуу.¹

Их хутагтын оюунаа болгоогдон, олон олон уран дархны ур хийц, ухаан, хичээлээр бүтсэн дээрх бүгд нь “Шашныг хамаг амьтны тусад харштай” хэмээн бурууд бодсон үйлийн гайгаар устан үгүй болсон бөгөөд харин зохиол, бүтээл тэргүүтэн нь Хутагтын хүрээ орон байрлан асан газар орны ойрноо жир сүсэгтэн ардын бурхан тахилын ширээнээ хадгалагдан байж болох...

Дүгнэлт

Их хутагт бээр уламжлалт бурханы шашин юугаан уламд дэлгэрүүлэн, бусдын тусын тулдаа буяныг зориулагч сахилтан нугууд эш онолоо сайтар судлан, их эв эеийг хичээн болгоож тэрчлэн хуврагийн замаар замнах нь номын ёсон болоод ертөнцийн явдал зүйд нийцэн буй хэмээн таалж байсан аж. “Ба бүрний багш”-ийн номлол сургаалын уг, мөн чанарыг хэлбэрэлтгүйд барин гайхамшигт номын ухаанаа шамдах нь дээдийн номыг үнэнхүүд онон барихын учир оршино хэмээн олонтаад цогдамлан лугаад хайрлаж асан болой.

Нэгэн зүйлийг тэмдэглэвээс, ганц Дамдинбазар хутагт ч бус дээд дүрийн бүрэлбаа нугууд ч мөнд адилаар бурханы номын шавийн хувьд хүрээ хийдийн дэг,

¹ Агваанлхасүрэн., Дурдсан намтар, 21 дэх тал.

ёсийг олон олноор шинэчлэн найруулж, зохион туурвиж асан нь намтар тэргүүтнээс харагдах агаад тэдгээрийг дор бүрд нээн бүртгэж, харьцуулан шинжилж нийтийн хүртээлд сөхөн тавихын учир буйг өгүүлсү.

Summary

The great being has remarked that it would be in accordance with both dharma conduct and worldly matters to further spread Buddhism as the traditional religion, and for ordained ones, those who work for the benefit of others, to further deepen their studies in dharma and be harmony with others, and follow the path of true monks. The great endeavor in realizing the unshakable root of the teachings of Buddha, lies in the absolute truth of dharma.

НОМ ЗҮЙ

1. "Bstan pa'i gsal byed Rgyal khang rtze'i sprul pa'i sku 'khrungs rabs mos ldan dad gsos zhes bya ba bzhugs so" (Шашныг гийгүүлэн үйлдэгч Жалханзын хувилгааны дүр, төрөл үеийн бишрэл, төгөлдрийн сүсгийг төлжүүлэгч хэмээгдэх оршивой) /төвд судар/
2. Ngag dbang blo bzang Ye she thub bstan /Агваанлуvsан-Иштүвдэн /., "Bstan pa'i gsal byed chen po Rgyal khang rtze rin po che rje Blo bzang dpal 'byor lhun grub kyi nam par thar bskal bzang rna ba'i bcud len zhes bya ba bzhugs so" (Шашныг ихэд гийгүүлэн үйлдэгч Жалханз их эрдэнэ богд Лувсанбалжирлхүндэвийн намтар, сайн хувьтны чихний шимийг авахуй хэмээгдэх оршивой) /төвд судар/
3. Ngag dbang lha srung /Агваанлхасүрэн/., "Rje btzun bla ma Rgyal khang rtze rin po che Blo bzang bstan 'dzin rgyal mtsan rta mgrin bajra dpal bzang po'i gsang gsum rmad du byung ba'i nam par thar ba 'dab brgya'i dga' tsal las cha shas tgam du byas pa pad dkar 'chun po legs tsogs sgo 'byed ces bya ba bzhugs so" (Гэтэлгэгч лам Жалханз их эрдэнэ Лувсанданзанжалцандамдинба-зарбалсамбуугийн нууц гурван гайхамшигтаас гарсан намтар, зуун дэлбээтийн цэцэрлэгээс хувь төдийг өгүүлэн үйлдсэн цагаан лянхуан баглаа сайн чуулганы үүдийг нээгч хэмээх оршивой). Цагаан лянхын баглаа сайн чуулганы хаалгыг нээгч,-хэвлэлд Бат-Эрдэнэ Б., УБ.,1994
4. Дилов хутагт Жамсранжав., Ар Монголын улс төрийн дурдатгал. УБ.,1991
5. Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг. УБ.,1995

6. Зарлигаар тогтоосон Монгол улсын шастар. Дэвтэр I. УБ., 1995
7. Зарлигаар тогтоосон Монгол улсын шастар. Дэвтэр II. УБ., 1996
8. Монголын философийн түүх (XVII-XIX зуун) III, IV дэвтэр, Ред: Лхагвясүэн Г., Дашжамц Д., УБ., 2001
9. Мягмарсүрэн Г., Самади багш, номун хан Жалханз хутагтын суддагаанд холбогдох зарим асуудал/бакалаврын дипломын ажил,-удирдагч Очирагч Г./, УБ., 2005
10. Хоёр их хутагт эмхэтгэл.-Хэвлэлд Очирбат Г., Лувсанцэрэн Г., В. Чулууннаатар, УБ., 1995

-
6. Зарлигаар тогтоосон Монгол улсын шастар. Дэвтэр I. УБ.,1995
 7. Зарлигаар тогтоосон Монгол улсын шастар. Дэвтэр II. УБ.,1996
 8. Монголын философийн түүх (XVII-XIX зуун) III, IV дэвтэр, Ред: Лхагвасүрэн Г., Дашжамц Д., УБ.,2001
 9. Мягмарсүрэн Г., Самади багш, номун хан Жалханз хутагтын судалгаанд холбогдох зарим асуудал /бакалаврын дипломын ажил,-удирдагч Очирбат Г./, УБ.,2005
 10. Хоёр их хутагт эмхэтгэл,-хэвлэлд Очирбат Г., Лувсанцэрэн Г., В. Чулуунбаатар, УБ.,1995